



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/542

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. "г", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөтгөн яаралтай тусламжийн дуудлагын нэгдсэн систем "Call center" үйлчилгээ нэвтрүүлэхэд шаардагдах өрөөний засварт 3,555,000, төрийн үйлчилгээг цахимаар хүргэх зорилгоор Үйлчилгээний нэгдсэн төв болон Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газарт киоск машин худалдан авах, суурилуулах зардалд 7,280,000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 10,835,000 (арван сая найман зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101231